



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 1 сарын 15 өдөр

Дугаар 13

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Ишдорж овогтой Цэрэн-Онолтыг Испани улсын Rovira I Virgili Их сургуулийн докторантурт компьютерийн ухааны чиглэлээр, Дорждагва овогтой Тамирыг Швейцари улсын Цюрихийн Их сургуулийн магистрантурт герман судлалын чиглэлээр, Дамчаа овогтой Түвшинтөрийг Итали улсын Кремона хотын Антонио Страдиварийн нэрэмжит Сонгодог хөгжмийн зэмсэгийн мастерийн сургуульд, Түмэн овогтой Төгсийг ОХУ-ын Дотоод Явдлын яамны дэргэдэх Удирдлагын академид тус тус 2 жилийн хугацаагаар 2002-2003 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Ядон улсын Чибагийн Их сургуулийн докторантурт суралцаж буй Санжаа овогтой Туяа, Австри улсын Ургамал судлалын хүрээлэнгийн докторантурт суралцаж буй Дашбалжир овогтой Ичинхорлоо, Их Британийн Эксетерийн Их сургуулийн магистрантурт суралцаж буй Цэдэв овогтой Цолмон нарын суралцах хугацааг тус тус нэг жилээр сунгасугай.

3. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

А.ЦАНЖИД